



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн давтан аудитын тайлан.



“Гавшгай-Ус” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн давтан аудитын тайлан

Ерөнхий дүгнэлт:

Авлага, өр төлбөр барагдуулах ажлын үр нөлөө муу байгаагаас үйл ажиллагаа явуулах тусам авлага, өр төлбөр нэмэгддэг сөрөг хандлага оршсоор байна.

Сүхбаатар сум 2017 он

Тайланг бэлтгэсэн:
Сэлэнгэ аймаг
дахь Төрийн
аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
С.Бат-Эрдэнэ

2017 оны 10 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
7036-2442 дугаарын
утас, 7036-3040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ
аймгийн Сүхбаатар
сум аймгийн ЗДТГ-
ын байрны
өргөтгөлд

Агуулга

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Хоёр. Үндсэн мэдээлэл
Гурав. Аудитын дүн

Бүлэг 1: Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, зөрчлийг бүрэн арилгасан уу ?

1.1. Өмнөх аудитаар тавигдсан актыг бүрэн барагдуулсан уу?
1.2. Албан шаардлагын биелэлтийг хангаж, зөрчлийг таслан зогсоосон эсэх?

Бүлэг 2: Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу ?

2.1. Аймгийн ИТХ, Засаг дарга, Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдэд өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн үү?

2.2. Компанийн гүйцэтгэх захирал, санхүүгийн ажилтнуудад өгөгдсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлсэн үү ?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Хавсралтууд

Холбогдох байгууллагын санал

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
СЭА	Сэлэнгэ аймаг
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДА	Давтан аудит
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.Аудитын нэр: “Гавшгай-Ус” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд хийх давтан аудит.

2.Аудитын код: СЭА-2017/02-ГА-ДА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

4.Аудитын зорилт:

2016 онд “Гавшгай-Ус” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- ❖ Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, зөрчлийг бүрэн арилгасан уу ?
- ❖ Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу ?

5.Аудитын хамрах хүрээ:

Аудитаар “Гавшгай ус” ХХК-ийн 2015, 2016 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар тавигдсан акт, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг, 2016 оны 9 сараас 2017 оны 8 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэв.

6.Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам”-ыг мөрдөж “Гавшгай-Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч болон бусад мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгий тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд, аудитын горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсруулав.

7.Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгохоос гадна дараах үзүүлэлтийг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- Компанийн тухай хууль

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”.

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ 2017 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 23-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн тайлангийн төсөлд санал авахаар 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 206 дугаар албан бичгээр хүргүүлэв.

“Гавшгай-Ус” ХХК-аас 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр тайлангийн төсөлд санал ирүүлсэнийг хянан үзэж холбогдох тайлбарыг тайланд тусгаж, аудитын тайланг 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулав.

9. Үндсэн мэдээлэл:

Тус компани нь Сайхан сумын төв дэх 6000 гаруй оршин суугчид Номгон тосгоны 2000 гаруй иргэд болон 130 гаруй аж ахуй нэгжийг цэвэр усаар хангах, аж ахуй нэгж байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж цэвэрлэх, Номгон тосгоны дулаан хангамжийг хариуцах үндсэн үүрэг хүлээн үйл ажиллагаагаа явуулж байна.

“Гавшгай ус” ХХК-ийн хөрөнгө, мөнгийг захиран зарцуулах 1-р гарын үсгийг гүйцэтгэх захирал Л.Балдорж, 2-р гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Ё.Батцэнгэл нар зурж байна.

2016 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар 29.5 сая төгрөгийн авлага барагдуулах акт, 501.7 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага, үр өгөөж, үр ашиг, арвилан хэмнэлтийг дээшлүүлэх 3 зөвлөмжийг компанийн ТУЗ-д, Аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн Засаг даргад 3 зөвлөмжийг, компанийн гүйцэтгэх захиралд 7 зөвлөмжийг, санхүү, бүртгэлийн ажилтнуудад 4 зөвлөмжийг тус тус өгсөн байна.

БҮЛЭГ:1

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, зөрчлийг бүрэн арилгасан үү ?

Компанийн удирдлагуудын зүгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн боловч аж ахуйн нэгж байгууллага иргэдээс авах авлагыг бууруулаагүй, нүүрс, шатахууны худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зэрэг зөрчил оршсоор байна.

1.1 Өмнөх аудитаар тавигдсан нөхөн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан уу ?

2016 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 29,485.9 мянган төгрөгийн зөрчилд 2 нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосноос 22,014.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, биелэлт 74.7 хувьтай байна.

1.1.1 Ажилтнуудад албан томилолтын зардлыг олгохдоо “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчилэн тогтоох” тухай Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг зөрчин зам хоног, байрны зардал олгосон боловч нэмж зочид буудлын зардалд илүү олгогдсон тул 7 ажилтанд **1,905.1** мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

1.1.2 Компанийн удирдлагууд болон санхүүгийн ажилтнуудтай холбоотой 2009-2015 онд үүссэн боловч барагдуулаагүй 5 ажилтанд 27,580.8 мянган төгрөгийн / цалингийн урьдчилгааны 9,550.8 мянган төгрөг, хүнсний материал, цементийн авлага 18,030.0 мянган төгрөг / төлбөрийн акт тогтоосноос тайлант хугацаанд 20,109.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, О.Буянаагийн 3,028.8 мянган төгрөгийн, М.Оюунбаярын 4,442.6 мянган төгрөгийн зэрэг нийт 7,471.4 мянган төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй байна. Дээрх нөхөн төлбөрийн актын үлдэгдлийг холбогдох хүмүүсээр тайлант онд төлүүлж дуусгах шаардлагатай байна.

1.2 Албан шаардлагын биелэлтийг хангаж, зөрчлийг таслан зогсоосон эсэх ?

Албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн зарим ажлын үр нөлөө муу байгаагаас олон жил хуримтлагдсан байгууллага, хувь хүнээс авах авлагыг бүрэн барагдуулаагүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зэрэг зөрчил арилаагүй байна.

Өмнөх гүйцэтгэлийн аудитаар нийт 501,711.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөрчил арилгуулах, 1 хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн бөгөөд тайлант хугацаанд 2 албан шаардлагыг бүрэн биелүүлж, 2 албан шаардлагыг хангалтгүй биелүүлснээс зөрчил бүрэн арилаагүй байна. Албан шаардлагын биелэлтийг нэг бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1.2.1 Компанийн үйл ажиллагаанд хамааралгүй, хандивын шинжтэй 4,090.1 мянган төгрөгийн зардал гаргасан, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар нийт 4,650.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, албан томилолтын үнэмлэх, томилолтоор ажилласан эсэхийг нотлох, дэмжих баримтгүйгээр 3,253.3 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон зэрэг нийт 11,993.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар албан шаардлагын хэрэгжилтийг шалгахын тулд мөнгөн хөрөнгийн зарцуулалтад түүвэр хийж үзэхэд ажилтнуудад дотоод албан томилолтын зардлыг олгохдоо Сангийн сайдын тушаалаар тогтоосон хэмжээнээс илүү тооцож, нийт 450.0 мянган төгрөгийн зочид буудлын зардал нэмж олгосон, гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүй, холбогдох анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 300.0 мянган төгрөгийн кассын зарлага хийж бүртгэлд тусгасан зөрчил илэрлээ.

Харин “Гавшгай-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгч байсан томилолтын зардлыг нотлох, дэмжих баримтгүйгээр олгосон, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хандив тусламж олгосон, зочин төлөөлөгч хүлээн авах зардал их хэмжээгээр гаргасан зэрэг зөрчлүүдийг бүрэн арилгасан байна.

1.2.2 Өмнөх аудитаар ЗГ-ын тогтоолоор баталсан босго үнийн дүнгээс давсан автомашин, нүүрс, шатахууны худалдан авалтыг үнийн харьцуулалт хийлгүйгээр шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн 202,069.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Давтан аудитад хамрагдсан тайлант хугацаанд тус компани ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан шууд худалдан авалтын босго үнийн дүнгээс давсан 23,000.0 мянган төгрөгийн сэлбэгийн худалдан авалт хийхдээ 3 аж ахуйн нэгжээс үнийн санал авч гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

Гэвч 2017 оны 8-р сарын байдлаар тайлант онд 21,503.6 мянган төгрөгийн нүүрсний, 29,839.8 мянган төгрөгийн түлш, шатахууны худалдан авалтыг үнийн харьцуулалт хийлгүйгээр гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1¹, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолын 2² дахь заалтыг дахин зөрчиж байна. Өөрөөр хэлбэл өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.2.3 Компанийн хөрөнгө, санхүүгийн нөөцийг зохистой удирдаагүй болон бүртгэлээр тавих хяналтыг сулруулснаас байгууллага, хувь хүн, ажилчдаас авах насжилт өндөртэй нийт 287,648.6 мянган төгрөгийн авлага үүссэн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Хэрэгжилтийг шалгахад 287,648.6 мянган төгрөгийн авлагаас тайлант хугацаанд 13.5 хувийг буюу 38,741.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 248,906.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

хүснэгт- 1 мян.төг

Дансны төрөл	Албан шаардлага бичигдсэн дүн	Төлөгдсөн авлага	Авлагын үлдэгдэл	эзлэх хувь
Байгууллагаас авах авлага	92,620.0	14,303.7	78,316.3	15.4
Хувь хүмүүсээс авах авлага	30,575.0	1,002.0	29,573.0	3.3
Ажилчдаас авах авлага	59,492.5	8,243.0	51,249.5	13.9
Ажилчдаас цалингийн авлага	12,776.0	2,834.2	9,941.8	22.2
Цементийн борлуулалтаас үүссэн авлага	92,185.1	12,359.0	79,826.1	13.4
Нийт дүн	287,648.6	38,741.8	248,906.8	13.5

¹ Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа ажил, үйлчилгээний дээд хязгаар.

² Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10 сая төгрөг.

Компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нараас дээрх албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа талаар шалтгааныг тодруулахад:

Дээрх 5 дансанд үүссэн авлагын дийлэнх нь 1998-2012 оны хооронд үүссэн насжилт өндөртэй байгаагаас зарим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хаяг байршил тодорхойгүй, зарим иргэн тухайн авлагыг хүлээн зөвшөөрөхгүй байх зэрэг хүндрэл бэрхшээлүүдээс шалтгаалж биелэлт хангалтгүй байна. Цаашид барагдуулах ажлыг эрчимжүүлж ажиллана гэсэн тайлбарыг өгсөн болно.

Компанийн удирдлага болон санхүүгийн ажилтнуудын зүгээс дээрх авлагын үлдэгдлүүдийг насжилт болон эргэн төлөгдөх боломжтой эсэх байдлаар ангилан дүн шинжилгээ хийж, барагдуулах талаар төлөвлөгөө гарган, арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

1.2.4 Удаа дараагийн хийж гүйцэтгэсэн аудитуудаар өгөгдсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй албан үүргээ хангалтгүй биелүүлж их хэмжээний алдаа, зөрчил гаргасан ерөнхий болон тооцооны нягтлан бодогчид, кассын няравт хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн байна.

Албан шаардлагын дагуу “Гавшгай ус” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 75 дугаар тушаалаар ерөнхий нягтлан бодогч О.Буянаа, нягтлан бодогч И.Цэвэлмаа, М.Оюун, кассын нярав М.Оюунбаяр нарт 1 сарын үндсэн цалинг 20 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулж, хариуцлага тооцсон байна.

БҮЛЭГ:2

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн зөвлөмжийн 65 хувь нь бүрэн хэрэгжсэн болон хэрэгжих шатандаа байгаа боловч, зарим зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөө муу байгаагаас компанийн санхүүгийн үйл ажиллагааны гол үзүүлэлт болох авлага, өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос буураагүй байна.

2.1 Аймгийн ИТХ, Засаг дарга, компанийн ТУЗ-ийн дарга гишүүдэд өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн үү ?

Аймгийн ИТХ, Засаг дарга нарын зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан боловч тус компанийн ТУЗ –өөс зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил хийгдээгүй байна.

2.1.1 Өмнөх аудитаар компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдэд 3 зөвлөмжийг хүргүүлсэн боловч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- ✓ Жил бүр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хүргүүлж, хэлэлцүүлж байх,

- ✓ ТУЗ-ийн зүгээс компанийн санхүүгийн үйл ажиллагаанд бодит хяналт, шалгалт хийж өглөг, авлагыг бууруулах арга хэмжээг авч ажиллах,
- ✓ Зөвхөн санхүүгийн тайлан дээрх, мөнгө нь орж ирээгүй ашгийг үндэслэн компанийн захиралд урамшуулал олгож буй тогтолцоог өөрчлөх, захирлын ажлын үзүүлэлтэд өглөг, авлага барагдуулалт, санхүүгийн зөрчил, холбогдох хяналтын байгууллагуудын үнэлэлт дүгнэлтийг авч үзэж байх.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 10 дугаар тогтоолоор Гавшгай-Ус ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг өөрчлөн томилсон боловч өмнөх аудитаар өгөгдсөн дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар хуучин болон шинэ бүрэлдэхүүний аль аль нь арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Тухайлбал: 2016 оны 2-р улиралаас хойш хуучин ТУЗ хуралдаагүй, шинээр томилогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн 2017 оны 3-р улиралын байдлаар 1 удаа л хуралдсан байгаа нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2013 оны 130 дугаар тогтоолоор баталсан “*Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах нийтлэг журам*”-ын 2.2³-д заасантай нийцэхгүй байна.

Шинээр томилогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж компанийн 2017 оны үйлдвэрлэлийн даалгавар, орлогын төлөвлөгөө, зардлын хуваарилалт, ТУЗ-ийн дарга, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ТУЗ-ийн 2017 оны төсөв батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж, тогтоолоор баталсан ба 2016 оны үйл ажиллагааны тайланг уг хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн боловч компанийн санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын дүгнэлт гараагүй тул хойшлуулсан байна.

Давтан аудитыг хийх хугацаанд буюу 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ТУЗ-ийн хурлаар тус компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, “Хангалттай сайн” гэж дүгнэсэн боловч насжилт өндөртэй өглөг, авлагыг барагдуулах болон үйлдвэрлэлийн үр дүнгээр бий болсон ашгийг хуваарилах талаар авч хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

2.1.2 Өмнөх хийж гүйцэтгэсэн аудитын дүнд үндэслэн Аймгийн ИТХ болон Засаг даргад хамаарах 3 төрлийн зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд үүнээс 2 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байна. Үүнд:

- ✓ “Гавшгай-Ус” ХХК-ийн ТУЗ-ийг шинэчлэн зохион байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч байх.
- ✓ “Гавшгай-Ус” ХХК-ийн удирдлагатай жил бүр гэрээ байгуулж бодитоор дүгнэж байх, компанийн санхүүгийн нөхцөл байдлыг хүндрүүлсэн, их хэмжээний санхүүгийн зөрчил гаргасан гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт хариуцлага тооцох.
- ✓ “Гавшгай-Ус” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, нөхцөл байдалд нь санхүүгийн шинжилгээ хийж цаашид хэрэгжүүлэх арга замыг бодитоор тодорхойлох.

³ 2.2 ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал бүр хуралдуулна.

Аудитын тайланд өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт аймгийн Засаг даргын 2017 оны 05-р сарын 31-ний өдрийн 1/566 дугаар, ЗДТГ-ын даргын 2017 оны 9-р сарын 12-ны өдрийн 2/393 дугаар, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын 2017 оны 06-р сарын 13-ны өдрийн 152, 2017 оны 09-р сарын 15-ны өдрийн 194 дүгээр албан бичгээр тус тус хариу ирүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 1-р сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор "Гавшгай-Ус" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Ж.Санжжав, гишүүдэд Аймгийн засаг даргын орлогч Ж.Сайнцог, Сайхан сумын засаг дарга О.Буянаа, "Гавшгай -Ус" ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Балдорж, Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн С.Чулуунцэцэг нарын 6 хүнийг шинэчилэн томилсон байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргил тус компанийн гүйцэтгэх захиралтай 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 2017 оны үр дүнгийн гэрээг байгуулсан бөгөөд гэрээг жилийн эцэст дүгнэхээр тусгагдсан байна. Компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах эрх, үүргийг үр дүнгийн гэрээний 2.1⁴, 6.1⁵-6.3 дахь заалтуудаар зохицуулж Орон нутгийн өмчийн газарт хариуцуулсан байна.

Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс 2017 оны 3-р улиралын байдлаар өр төлбөр, авлагын үлдэгдэл, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх тайлан, судалгааг авсан байна. Дээрх судалгаанд үндэслэн 2017 оны 4-р улиралд багтаан өр, авлага өндөртэй аж ахуйн нэгж байгууллагуудын үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийхээр төлөвлөж байна гэсэн тайлбарыг тус газрын дарга өгсөн болно.

"Гавшгай ус" ХХК-ийн гүйцэтгэх захиралын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 75 дугаар тушаалаар ерөнхий нягтлан бодогч О.Буянаа, нягтлан бодогч И.Цэвэлмаа, М.Оюун, кассын нярав М.Оюунбаяр нарт 1 сарын үндсэн цалинг 20 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг ногдуулж хариуцлага тооцсон боловч Аймгийн Засаг дарга болон ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх захиралд хариуцлага тооцоогүй байна.

2.2 Компанийн гүйцэтгэх захирал, санхүүгийн ажилтнуудад өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн үү ?

Компанийн гүйцэтгэх захирал болон санхүүгийн ажилтнуудад нийт 11 зөвлөмж хүргүүлсэнээс тайлант хугацаанд 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа бол 4 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

⁴ 2.1 Аймгийн Засаг дарга Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл болон хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлж, Орон нутгийн өмчийн газраар дамжуулан хяналт тавьж ажиллана.

⁵ 6.1 Орон нутгийн өмчийн газар үйлдвэрийн газрын захирлын үйл ажиллагаанд байнгын хяналт тавина.

6.2 Үйлдвэрийн газрын тухайн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан захирлын захиран зарцуулах зардлын хэмжээг баталж өгнө.

2.2.1 Компанийн гүйцэтгэх захиралд дотоод хяналт болон байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах талаар нийт 7 төрлийн зөвлөмжийг өгсөн байна.

Компанийн гүйцэтгэх захиралд өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж, холбогдох материалтай танилцаж, дүгнэхэд 2 зөвлөмж хэрэгжсэн, 3 зөвлөмж хэрэгжих шатандаа, 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

- ✓ Эрчим хүчний тухай хуулийг зөрчин дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлгүйгээр “Цемент шохой” ХК-ийн өмнөөс дулаан борлуулж буй үйл ажиллагааг хууль, эрхийн актад нийцүүлэх,

“Гавшгай-Ус” ХХК-ийн зүгээс 2015 оноос хойш Хөтөлийн “Цемент шохой” ХХК-ийн үйлдвэрлэсэн дулааныг айл өрхүүдэд дамжуулан борлуулах гэрээг цуцлах хүсэлтийг тус компанид удаа дараагийн албан бичгээр хандаж ирсэн боловч Хөтөлийн “Цемент шохой” ХК-ийн зүгээс уг асуудалд хариу өгөлгүй 2017 оныг хүргэсэн байна.

“Гавшгай ус” ХХК 2017 оны 02-р сарын 02-ны өдрийн 14 дугаар албан бичгээр 2017 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн айл өрхийн дулааны борлуулалтыг хариуцахгүй болохыг Хөтөлийн “Цемент шохой” ХХК-д мэдэгдэж 2017 оны 5-р сарыг дуустал дулаан борлуулалтын бичилтийг гүйцэтгээгүй байна. Гэвч Хөтөлийн “Цемент шохой” ХХК-ийн зүгээс уг гэрээг цуцлахаас татгалзсан хариуг 2017 оны 02-р сарын 20-ны өдрийн 01/173 дугаар албан бичгээр ирүүлж, улмаар айл өрхийн дулаан борлуулалтын бичилтийг 2 тал хариуцалгүй 6-р сарыг хүртэл явсанаас айл өрхөөс авах дулааны авлага улам хуримтлагдаж байна. Үүний улмаас “Гавшгай –Ус” ХХК-д борлуулалтын орлого цаг хугацаандаа орж ирэхгүй байх, бэлэн мөнгөний эргэлт удааширч санхүүгийн хүндрэл үүсгэж үйл ажиллагаа доголдоход хүргэсэн тул дулаан дамжуулан борлуулалтыг 2017 оны 6-р сараас дахин хариуцаж ирсэн байна.

Уг асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг компанийн ТУЗ, Сайхан сумын Засаг даргад 2017 оны 02-р сарын 21-ний өдрийн 22, 23 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн байна. Хөтөлийн “Цемент шохой” ХХК-иас 2017 оны 06-р сарын 02-ны өдрийн 01/524 дугаар албан бичгээр дулааны эрчим хүчээр хангах, дамжуулан борлуулах гэрээг сунгах хүсэлт ирүүлснийг “Гавшгай-Ус” ХХК-ийн зүгээс 2 талын ажлын хэсэг гаргаж цаашид хэрхэн хамтран ажиллах, өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд 2014-2015 онд байгуулагдсан уг гэрээг сунгахаа мэдэгдэж, гэрээний төслөө хүргүүлсэн байгаа боловч одоогоор гэрээнд өөрчлөлт ороогүй байна.

Цаашид уг асуудлыг компанийн ТУЗ болон төр, захиргааны удирдах байгууллагуудаар дамжуулан шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай юм.

- ✓ Компанийн ойрын болон хэтийн бизнес стратегийн төлөвлөгөөг боловсруулж, түүний гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх замаар үйлдвэрлэл, үйл ажиллагааг үр ашигтай эрхлэх,

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 2017 оны компанийн жилийн бизнес төлөвлөгөөг дэлгэрэнгүй байдлаар боловсруулж ТУЗ-өөр батлуулсан байгаа боловч урт хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулаагүй байна. Холбогдох албан тушаалтнуудаас шалтгааныг тодруулахад ижил төстэй байгууллагын стратеги төлөвлөгөөтэй танилцаж, туршлага судалж байгаа, энэ ондоо багтаан боловсруулна гэсэн тайлбарыг өгсөн болно.

- ✓ Хөрөнгийн зарцуулалтад үр ашиг, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримталж, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах,

Дээрх зөвлөмжийн хүрээнд инженер, техникийн ажилтнууд 987 айл өрхөөр орж шугам, хоолойн үзлэг шалгалт хийн, 309 айл өрхөд зөрчил илрүүлж, усны алдагдлыг багасгасан, ам бүлийн бүртгэл дээр хяналт тавьж 65 айл өрхийн ам бүлийн тоог 134 хүнээр нэмэгдүүлж, сарын орлогыг эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна. Мөн цахилгааны гурван шатны тоолуур тавьж өргөх станцуудын дамжуулан шахах насосуудыг шөнийн горимд ажиллуулах хуваарь гарган ажиллуулса нь цахилгааны зардлыг урьд оны гүйцэтгэлээс 34,413.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж зочин төлөөлөгч хүлээн авах болон хандив тусламж олгохгүй байхад анхаарч ажилласан байна.

- ✓ Бараа материал, үүний дотор сэлбэг хэрэгслийг хэрэгцээнээс хэт ихээр нөөцөлж, мөнгөний эргэлтийг сааруулж буй зөрчлийг таслан зогсоох,

Бараа материалын 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 1.9 хувиар өссөн бол 2017 оны 8-р сарын 31-нээрх үлдэгдэл 2016 оноос 24,804.1 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

хүснэгт- 2 мян.төг

Дансны нэр	2016.12.31				2017.08.31		
	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
Химийн бодис	5,857.9			5,857.9	1,386.6	3.0	7,241.5
Аж ахуйн материал	12,000.9	24,327.0	28,165.3	8,162.6	12,106.2	13,546.6	6,722.1
Шатахуун	-	65,449.0	65,449.0	0.0	29,839.8	29,839.8	0.0
Тослох материал	369.7	80.0	389.7	60.0		48.8	11.1
Нүүрс	-	70,998.7	70,998.7	0.0	21,503.6	21,503.6	0.0
Цахилгааны сэлбэг	51,923.5	27,872.2	23,867.0	55,928.7	10,133.2	16,992.3	49,069.6
Насосны сэлбэг	137,666.2	79,628.1	84,178.5	133,115.7	30,022.0	28,811.8	134,325.9
Автын сэлбэг	1,077.9	4,881.0	4,531.0	1,427.9	9,771.6	9,684.6	1,514.9
Сантехникийн сэлбэг	68,753.3	33,981.5	21,598.8	81,136.0	20,047.7	19,683.2	81,500.4
Хүнсний материал	1,836.4	30,578.4	31,720.0	694.8	11,901.2	12,490.7	105.4
БҮТЭЗ	25,638.2	25,981.1	31,522.1	20,097.2	15,635.7	18,239.5	17,493.4
Ашиглалтанд байгаа БҮТЭЗ	46,014.3	3,523.0	668.0	48,869.3	1,200.0	16,508.7	33,560.6
Токарын сэлбэг	6,078.4	4,826.6	2,161.3	8,743.7	235.0	1,498.5	7,480.2
бусад	232.9	5,080.5	4,958.8	354.5	805.1	540.5	619.1
Нийт дүн	357,449.5	377,207.0	370,208.3	364,448.3	164,587.6	189,391.7	339,644.2

Бараа материалын 2017 оны 08-р сарын нийт үлдэгдлийн 14 хувийг цахилгааны сэлбэг, 40 хувийг насосны сэлбэг, 24 хувийг сантехникийн сэлбэгийн материал, 12 хувийг бусад бараа материал тус тус эзэлж байна.

Өмнөх аудитаар цахилгааны болон сантехникийн сэлбэг хэрэгслийг хэрэгцээнээс илүү худалдан авч нөөцөлж мөнгөн хөрөнгийн эргэлтийг удаашруулсан зөрчил илэрсэн тул дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгсөн байна.

Давтан аудитад хамрагдсан тайлант хугацаанд жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан их болон урсгал засварын ажил болон гэнэтийн эвдрэл, гэмтэлд шаардлагатай сэлбэг хэрэгслийг худалдан авах бодлого баримтлан ажилласан байна. 2017 онд 10,133.2 мянган төгрөгийн цахилгааны сэлбэг худалдан авч 16,992.3 мянган төгрөгийн зарцуулалтыг, 20,047.7 мянган төгрөгийн сантехникийн сэлбэг худалдан авч 19,683.2 мянган төгрөгийн зарцуулалтыг, 30,022.0 мянган төгрөгийн насосны сэлбэг худалдан авч 28,811.8 мянган төгрөгийн зарцуулалтыг хийсэн байна.

- ✓ Олон жилийн насжилттай авлагыг барагдуулж, өглөгийг бууруулах үр дүнтэй ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд биечлэн хяналт тавьж ажиллах, хуулийн байгууллагад шилжүүлэх,
- ✓ Компанийн ажилтнуудтай холбоотой үүссэн авлагыг нэн даруй барагдуулж, компанийг хохиролгүй болгох.

Тус компанийн авлага өмнөх аудитын тайлант хугацаанд буюу 2016 оны 04-р сарын байдлаар 1,175,052.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2016 оны жилийн эцэст 1,219,802.6 мянган төгрөгийн, 2017 оны 8-р сарын байдлаар 1,374,763.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу жил ирэх бүр өссөн үзүүлэлттэй тайлагнагдсан байна. 2017 оны 8-р сарын үлдэгдлийг 2016 оны 4-р сарын үлдэгдэлтэй харьцуулахад 17,0 хувиар өссөн байна.

хүснэгт- 3 мян.төг

Дансны төрөл	2015.12.31	2016.04.30	2016.12.31	2017.08.31	2016.04.30/ 2017.08.31 өсөлт, бууралт /хувиар/
Усны авлага	383,377.3	453,417.3	450,601.70	475,011.7	104.
Байгууллагын авлага	91,630.4	92,620.0	81,793.77	87,995.8	95.0
Цалингийн авлага	21,950.1	24,383.8	7,205.03	9,093.8	37.3
Оршин суугчдын усны авлага	429,062.9	492,688.4	568,408.49	699,312.9	141.9
Хүмүүсийн авлага	30,540.7	30,575.0	29,573.04	29,573.0	96.7
Дараа тайлангийн авлага	2,250.0	2,395.8	2,250.00	4,828.7	201.5
Ажиллагсдын өр	78,177.8	77,522.6	79,970.62	68,947.1	88.9
Бусад	979.8	979.8	-	-	-
ААНОАТ	469.5	469.5	-	-	-
Нийт дүн	1,038,438.7	1,175,052.3	1,219,802.6	1,374,763.0	117.00

Хүснэгтээс үзэхэд байгууллагын авлага, цалингийн авлага, хүмүүсийн авлага, ажиллагсдаас авах зэрэг авлагууд тодорхой хэмжээгээр буурсан бол усны

борлуулалтын авлага 46 хувиар өссөн байна. Энэ нь 2017 оны 1-6 сарын хооронд Цемент-шохой компанийн айл өрхөд борлуулж буй дулааны бичилтийг хийгээгүйгээс тус компанид борлуулсан усны үнийг авч чадаагүйгээс голлон шалтгаалсан байна.

Компанийн удирдлагуудын зүгээс өр, авлага барагдуулах талаар дараах ажлуудыг зохион байгуулсан байна.

2017 оны 3-р сард 22,812.8 мянган төгрөгийн өглөгтэй 15 айл, өрхийг шүүхэд шилжүүлсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2017 оны 3-р сарын 10-ны өдрийн 20 дугаар тушаалаар 10 инженер техникийн ажилтнуудад 51,643.0 мянган төгрөгийн өртэй 30 айл өрхийн өр төлбөрийг барагдуулах үүрэг өгч, 6,693.7 мянган төгрөгийн орлого цуглуулсан байна.

Өмнөх аудитаар ажиллагсадтай холбоотой авлага болон цалингийн авлагын дансанд өмнө ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа ажилтнуудын нэр дээр нийт 72,268.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд гүйцэтгэлээр 61,191.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тус компанийн өглөг 2016 оны 4-р сарын 30-ны өдрөөр 1,191,645.1 мянган төгрөг байсан бол 2017 оны 08-р сарын 31-ний байдлаар 1,258,015.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

хүснэгт- 4 мян.төг

Дансны төрөл	2015.12.31	2016.04.30	2016.12.31	2017.08.31
Байгууллагын өглөг	47,598.1	48,524.0	49,929.2	64,283.4
Цалингийн өглөг	46,285.7	94,787.8	2,409.9	39,617.4
Оршин суугчдын өглөг	2,088.6	1,302.2	3,086.5	3,122.5
Бусад	7,986.6	8,536.2	5,774.1	3,774.1
Дараа тайлангийн өглөг	34.0	187.2	2,346.8	2,219.0
ААХ-ийн өглөг	6,013.2	20,729.9	5,650.0	5,870.5
ОНО –ийн	7,812.7	7,812.7	7,812.7	7,812.7
Ноогдол ашгийн татвар	1,951.2	20,194.5	14,113.4	1,951.2
НӨАТ	286,592.9	255,876.0	299,271.8	251,840.6
ХАОАТ	162,264.4	179,876.0	195,007.2	194,833.0
ҮХХТатвар	3,546.2	3,546.2	3,545.4	45.4
ААНОАТ	-	-	1,374.7	670.7
Тээврийн хэрэгсэл	133.4	133.4	330.7	330.7
Газар	-	-	586.7	586.7
Бууны татвар	-	-	16.0	-
НДШ	501,744.1	550,139.1	609,925.4	681,057.6
Нийт дүн	1,074,051.0	1,191,645.1	1,201,180.4	1,258,015.4

Өглөгийн үлдэгдлийг бүтцийн хувьд авч үзэхэд 54.1 хувийг НДШ-ийн, 35.6 хувийг НӨАТ, ХХОАТ-ын, 10.3 хувийг бусад өглөг эзэлж байна.

Авлага цуглуулалт удаашралтай байгаагаас шалтгаалан өр төлбөр нийт дүнгээрээ багасаагүй байна. Өөрөөр хэлбэл авлага, өглөгийг барагдуулах талаар дорвитой арга хэмжээ авч, хэрэгжүүлэхгүй байгаагаас эдгээр нь буурах бус үйл

ажиллагаа явуулах тусам нэмэгдэх хандлагатай байгаа нь өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

- ✓ Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллах ,

2017 онд нүүрс, шатахууны худалдан авалтыг аж ахуйн нэгж байгууллагуудаас үнийн санал авч харьцуулалт хийлгүйгээр шууд гэрээгээр гүйцэтгэсэн бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
/Дэлгэрэнгүйг тайлангийн 1.2.2 дэх хэсэгт тусгасан байгаа/

2.2.2 Тус компанийн эдийн засагч, ерөнхий нягтлан бодогч болон бусад санхүүгийн ажилтнуудад нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулах талаар 4 төрлийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Санхүү, бүртгэлийн ажилтнуудтай холбоотой өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж, холбогдох материалтай танилцаж, дүгнэхэд 1 зөвлөмж бүрэн хэрэгжсэн, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

- ✓ Санхүүгийн тайлан, мэдээнд санхүүгийн шинжилгээ хийж авлага барагдуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх,

Санхүүгийн тайланд санхүүгийн шинжилгээ хийж төлөвлөгөө боловсруулсан ямар нэгэн ажил хийгдээгүй байна.

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,389,672.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээний угсралтын ажил”, Сайхан сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 79,804.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөтөл хотын инженерийн шугам сүлжээний хэсэгчилсэн ТК8-ТК хүртэлх засварын ажил” зэрэг хөрөнгө оруулалтын ажлуудыг капиталжуулж хөрөнгийн бүртгэлд тусгах,

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Хөтөл хотын доторх инженерийн шугам сүлжээний угсралтын ажил”-ыг улсын комисс хүлээн авч ашиглагч байгууллага болох “Гавшгай-Ус” ХХК-ийн мэдэлд шилжүүлсэн боловч одоог хүртэл хөрөнгийн орлогоор бүртгээгүй байгаа нь дээрх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна гэж үзэхэд хүргэлээ.

- ✓ Эргэлтийн хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу жилд 2 удаа хийж үлдэгдлийг баталгаажуулж байх,

“Гавшгай Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2016 оны 12-р сарын 28-ны өдрийн 99 дүгээр тушаалаар 2016 оны жилийн эцсийн, 2017 оны 07-р сарын 05-ны өдрийн 66 дугаар тушаалаар 2017 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгийн болон эргэлтийн хөрөнгийн тооллого хийх комиссыг тус бүр 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, гүйцэтгүүлсэн байна.

✓ НББ-ийн программыг НББОУС-тад нийцүүлэн шинэчлэх,

Тус компанийн ашиглаж байгаа Түшиг санхүүгийн програм нь санхүүгийн тайланг алдаатай нэгтгэж илэрхийлдэг, мөнгөн хөрөнгийн журналуудыг хэвлэхэд гүйлгээний он сар өдрийг зөрүүтэй гаргадаг, бараа материалын журналууд нь код давхцах, үнийн зөрүүтэй илэрхийлдэг, нярвын програм байхгүйгээс нэр төрлийн тайланг нягтлан бодогч шивдэг, НББОУС болон сангийн сайдын баталсан НББ-ийн журам, заавартай нийцүүлсэн өөрчлөлтүүд хийгдээгүй зэрэг дутагдалтай тул НББ-ийн програмыг шинэчилж өөрчлөх зөвлөмжийг өмнө хийгдсэн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитуудаар хүргүүлсэн байна.

Зөвлөмжийн дагуу 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “Би Ти Солюшн” ХХК-тай гэрээ байгуулан 5,500.0 мянган төгрөгөөр Silicon Accounting 3.0 програмыг худалдан авсан байна. Аудитын явцад уг програмын ашиглалтыг тодруулахад бүртгэлийн ажилтнуудыг програмын сургалтад хамруулж, 2017 оны эхний үлдэгдлийг оруулсан байна.

Иймд 2017 оны 4 дүгээр улиралд багтаан 2017 оны ажил, гүйлгээг Силикон 3.0 програмаар бүртгэж, жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээг боловсруулах, байгууллагын НБББББ-т 2010 оноос хойш өөрчлөлт хийгдээгүй байгаа тул шинээр боловсруулан өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

Илрүүлсэн зөрчил

2016 онд хийгдсэн “Гавшгай-УС ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлагыг бүрэн биелүүлээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар нийт 29,485.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 7,471.4 мянган төгрөгийг актыг барагдуулаагүй байна.
2. Аудитаар нийт 4 албан шаардлага өгсөнөөс 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн бол 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсаар байна.(Шатахуун, нүүрсний худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулаагүй, компанийн хөрөнгө, санхүүгийн нөөцийг зохистой удирдаагүй болон бүртгэлээр тавих хяналтыг сулруулснаас үүссэн байгууллага, хувь хүн, ажилчдаас авах насжилт өндөртэй нийт 287,648.6 мянган төгрөгийн авлагаас тайлант хугацаанд 13.5 хувийг буюу 38,741.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 248,906.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.)
3. Аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргад 3 зөвлөмж өгсөнөөс 2 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 1 нь хэрэгжих шатандаа байна.
4. Компанийн ТУЗ-д өгөгдсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
5. Компанийн захирал, санхүү, бүртгэлийн ажилтнуудад нийт 11 зөвлөмж өгсөнөөс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бол 4 зөвлөмж хэрэгжих шатандаа, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Үйл ажиллагаа явуулах бүр авлага, өр төлбөр нэмэгддэг зөрчил давтагдсаар байна.
2. Шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авалтуудын гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулахгүй байх зөрчил оршсоор байна.
3. Компанийн удирдлага, санхүүгийн ажилтнуудаас авах авлагыг бүрэн барагдуулаагүй байна.
4. Байгууллага, хувь хүн, ажилчдаас авах насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүйгээс дорвитой буурахгүй байна.
5. Компанийн ТУЗ –д өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил хийгдээгүй байна.
6. Аймгийн ИТХ болон Засаг даргад өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

- Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт болон зөрчил арилгуулах албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь бүрэн биелүүлээгүй “Гавшгай ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал Л. Балдоржид холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд:

- Тус компанийн дүрэм болон аймгийн ИТХ-ын 2013 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах,
- “Гавшгай-Ус” ХХК нь “Цемент шохой” компанийн үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчийг айл өрхүүдэд дамжуулан борлуулах үйл ажиллагааг дулаанаар зохицуулалттайгаар хангах тусгай зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэж байгаа, үүнээс шалтгаалж байгууллагын авлага улам бүр нэмэгдэж санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаа асуудлыг холбогдох хууль эрхийн хүрээнд нийцүүлж шийдвэрлэх арга хэмжээ авч, хэрэгжүүлэх.

Гүйцэтгэх захирал Л.Балдоржид :

- *Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.*

Ерөнхий нягтлан бодогч Ё.Батцэнгэл :

- *2017 оны 4 дүгээр улиралд багтаан Силикон 3.0 санхүүгийн програмыг бүртгэлийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэх.*

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БАТ-ЭРДЭНЭ



**СЭЛЭНГЭ АЙМАГ САЙХАН СУМ
"ГАВШГАЙ УС" ХХКОМПАНИ**

2056194 Утас: 70368287, Факс: 70368354
E-мэйл: hutulgavshgaius@yahoo.com

2017-11-13 № 114

Танай _____-ны № _____-т

г 1

Аудитын тайлангийн төслийн санал

Сэлэнгэ аймаг дахь Төрийн Аудитын Газрын байгууллагын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Тус байгууллагын үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн давтан Аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төсөлд тусгагдсан ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8 дугаар зүйлийн 8,1,1¹, 3Г-ын 2013 оны 68 дугаар тогтоолын 2² заалтыг дахин зөрчсөн байна гэсэн дүгнэлтэнд тайлбар хийж байна.

Тус сумын нутаг дэвсгэр дээр 4 аж ахуйн нэгжийн шатахуун түгээх станц борлуулалт хийж байгаа бөгөөд үнийн судалгаа дүгнэлт хийсний үндсэн дээр "Тэс петропиулим" шатахуун түгээх станцаас шатахууны төрөл бүрийн литр тутмаас 50 төгрөг бууруулж гэрээ байгуулан худалдан авалтаа хийж байгаа болно. Гэхдээ энэ нь аудитын дүгнэлтэнд тусгагдсан заалтуудын шаардлага хангасан үйл ажиллагаа болохгүй байна гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Цаашид хуульд нийцүүлэн худалдан авалтыг гүйцэтгэж байх болно.

Үнийн судалгаа хийсэн харьцуулалтыг хавсаргав.

1 литрийн үнэ

№	Шатахууны нэр төрөл	Шунхлай	Магнай трейд	Петровис	Тэс петропиуим	
					мөрддөг	Гэрээгээр
1	А-92 Бензин	1620	1650	1640	1630	1580
2	А-80 Бензин	1480	1500	1490	1480	1430


3	Д/Түлш	1710	1750	1720	1720	1670
4	Мобиль масло	9000	9000	8000	9000	9000
5	Ас-8 масло			3775	3800	3800

Нүүрсний худалдан авалтын тухайд манай цэвэр бохир усны борлуулалтын 70 гаруй хувийг бүрдүүлдэг "Цемент Шохой" ХК –иас "Номгон" тосгоны дулааны төвийн нүүрсийг хоорондын тооцоогоор татаж байна. Манай байгууллага нь нүүрс татах төмөр зам, буулгах цэггүйгээс гадна "Цемент Шохой" ХК нь хуурай аргын технологид шилжсэнээр улирлын чанартай борлуулалт хийж төлбөрөө цаг хугацаанд нь барагдуулж чадахгүй гэх мэтчилэнгийн орон нутгийн онцлог чанартай үйл ажиллагаануудаас шалтгаалан ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8 дугаар зүйлийн 8,1,1¹, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолын 2² заалтыг зөрчиж байгаа алдаа гаргасныг судлаж үзэхийг хүсэж байна.

Байгууллага, хувь хүн, ажиллагсдаас авах насжилт өндөртэй авлага нь тайлант хугацаанд 13,5 хувиар буурч 248,906,8 төгрөгийн үлдэгдэл байгаад үе шаттай ажил зохиож авлагыг бууруулах ажлыг эрчимжүүлж ажиллах болно.

Байгууллагаас авах авлагад судалгаа хийхэд насжилт өндөртэй авлагыг хаяг тодруулж, шүүхээр барагдуулах 63,812,441,0 төгрөг, барагдуулах боломжтой 14,503,816 төгрөгийг барагдуулах, Хувь хүмүүсээс авах 29,573,0 төгрөгийг хаяг тодруулж барагдуулах, Ажиллагсдаас авах авлагаас 10,363,663,0 төгрөгийг шүүхэд шилжүүлж шийдвэрлэх, нас барсан 4 хүний 914,916,0 төгрөгийг шүүхэд өгч шийдвэрлүүлэх, Борлуулалтаас үүссэн авлагаас 6 ААНэгжийн 39,400,571,0 төгрөгийг хаяг тодруулж барагдуулахын зэрэгцээ бусад авлагуудыг барагдуулж ажиллах болно..

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л. БАЛДОРЖ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

- Аудитын тайлангийн төслийн нэгдүгээр бүлгийн 1.2.2 –дахь хэсэгт Гэвч 2017 оны 8-р сарын байдлаар тайлант онд 21,503.6 мянган төгрөгийн нүүрсний, 29,839.8 мянган төгрөгийн түлш, шатахууны худалдан авалтыг үнийн харьцуулалт хийлгүйгээр гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1⁶, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолын 2⁷ дахь заалтыг дахин зөрчиж байна.

ТАЙЛБАР: Тус сумын нутаг дэвсгэрт 4 аж ахуйн нэгжийн шатахуун түгээх станц борлуулалт хийж байгаа бөгөөд үнийн судалгаа хийсний үндсэн дээр “Тэс петролиум” ХХК-ийн ШТС-аас шатахууны төрөл бүрийн 1 л тутмаас 50 төгрөг бууруулж гэрээ байгуулж худалдан авалтаа гүйцэтгэсэн болно. Энэ нь хуульд бүрэн нийцэхгүй байгаа тул цаашид хуулийн хүрээнд худалдан авалтыг гүйцэтгэх болно.

-Нүүрсний худалдан авалтын тухайд манай байгууллагын цэвэр бохир усны борлуулалтын 70 гаруй хувийг бүрдүүлж байгаа “Цемент шохой” ХХК –иас хоорондын тооцоогоор худалдан авалтыг гүйцэтгэж байгаа. Мөн манай байгууллагын хувьд нүүрс татах төмөр зам, буулгах цэггүйгээс гадна “Цемент шохой” ХХК нь хуурай аргын технологид шилжсэнээр улиралын чанартай борлуулалт хийж усны төлбөрөө цаг хугацаанд нь барагдуулж чадахгүй байх зэрэг шалтгааны улмаас нүүрсний худалдан авалтыг гүйцэтгэхдээ ТБОНӨХБАҮХТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолын 2.2 заалтыг зөрчиж байгааг судлаж үзэхийг хүсэж байна.

Аймгийн Аудитын газрын тайлбар:

Давтан аудитаар хөрөнгө, материалын худалдан авалтыг хуулийн дагуу явуулсан эсэхийг шалгахад шатахууны худалдан авалтыг харьцуулалтын аргаар гүйцэтгэснийг нотлох ямар нэгэн баримт материал ирүүлээгүй болно.

“Цемент шохой” ХХК-аас орж ирэх борлуулалтын орлого цаг хугацаандаа төвлөрдөггүйгээс бэлэн мөнгөний хомсдол үүсдэг, нүүрс тээвэрлэх төмөр зам, буулгах талбай байхгүй зэрэг хүндрэл бэрхшээл хэдийгээр байгаа боловч эдгээр нь босго үнийн дүнгээс давсан хөрөнгийн худалдан авалтыг гүйцэтгэхдээ ТБОНӨХБАҮХТ болон ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн журмыг мөрдөхгүй байх үндэслэл болохгүй юм. Иймээс хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулах шаардлагатай юм.

⁶ Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа ажил, үйлчилгээний дээд хязгаар.

⁷ Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10 сая төгрөг.